

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Чойбалсан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ДОА-2024/06/НА-СТА-ТТЗ**

|   |  |
|---|--|
| <p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br/>Чойбалсан хот<br/>2024 он</p> | <p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br/>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br/>Утас: 7058-4203, Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a><br/>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br/>Утас: 7058-4204, Цахим хаяг: <a href="mailto:semjidmaai@audit.gov.mn">semjidmaai@audit.gov.mn</a><br/>Ахлах аудитор: Д.Нармандах<br/>Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:narmandakhd@audit.gov.mn">narmandakhd@audit.gov.mn</a></p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Аудитын илрүүлэлт .....
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ИТХ      | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                                |
| ЗДТГ     | Засаг даргын Тамгын газар                                   |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                                   |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТТЗ      | Төсвийн төвлөрүүлэн захирагч                                |
| ХХС      | Хоршоо хөгжүүлэх сан  |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

№ 314

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЧОЙБАЛСАН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
П.АМГАЛАНБААТАР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чойбалсан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чойбалсан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

#### Аудитын гол асуудал

Тус сум нь 2023 оныг "Гэр бүл хүүхдийн хөгжлийг дэмжих" жил болгон хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд нийт 3 зорилтын хүрээнд 165 арга хэмжээ хэрэгжүүлэн ажилласан. Сумын ИТХ-ын 2023 оны 77 дугаар тогтоолоор 82.9 хувь буюу хангалттай гэж дүгнэсэн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Тайлант оны 984.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй байна.

"Хулстай хөгжил" ОНӨААТҮГ нь 2023 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, "Х" тайлан ирүүлсэн.

011021177

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код:     | Тайлангийн үзүүлэлт                                | 2022оны<br>12-р сарын 31 | 2023 оны<br>12-р сарын 31 |
|----------|--|--------------------------|---------------------------|
| <b>1</b> | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                     | <b>912,695.70</b>        | <b>701,773.70</b>         |
| 31       | МӨНГӨН ХӨРӨНГӨ                                     | 565,790.90               | 162,367.30                |
| 33       | АВЛАГА   | 76,693.80                | 194,003.50                |
| 35       | БАРАА МАТЕРИАЛ                                     | 270,211.10               | 345,402.80                |
| <b>2</b> | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                 | <b>1,725,085.10</b>      | <b>4,446,384.40</b>       |
| 39       | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                                     | 1,725,085.10             | 4,446,384.40              |
| 39200    | Биет хөрөнгө                                       | 1,673,160.60             | 2,377,061.20              |
| 39300    | Биет бус хөрөнгө                                   | 51,924.50                | 2,069,323.20              |
| <b>3</b> | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                 | <b>2,637,780.80</b>      | <b>5,148,158.00</b>       |
| <b>4</b> | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                              | <b>4,434.60</b>          | <b>15,321.70</b>          |
| 41       | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                          | 4,434.60                 | 15,321.70                 |
| 41300    | Өглөг  | 4,434.60                 | 15,321.70                 |
| <b>5</b> | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                    | <b>2,633,346.20</b>      | <b>5,132,836.30</b>       |
| 51       | Засгийн газрын хувь оролцоо                        | 2,633,346.20             | 5,132,836.30              |
| 51100    | Засгийн газрын оруулсан капитал                    | 471,616.30               | 2,489,431.50              |
| 51200    | Хуримтлагдсан үр дүн                               | 2,033,166.90             | 2,528,969.10              |
| 51300    | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                   | 128,563.00               | 114,435.80                |
| <b>6</b> | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b>2,637,780.80</b>      | <b>5,148,158.00</b>       |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код:       | Тайлангийн үзүүлэлт                                      | 2022оны<br>12-р сарын 31 | 2023 оны<br>12-р сарын 31 |
|------------|--|--------------------------|---------------------------|
| <b>I</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                   | <b>2,647,061.60</b>      | <b>2,687,083.50</b>       |
| 11         | ТАТВАРЫН ОРЛОГО  | 377,808.60               | 701,556.40                |
| 110        | Орлогын албан татвар                                     | 177,363.50               | 216,436.70                |
| 1100       | Хувь хүний орлогын албан татвар                          | 187,319.00               | 226,425.80                |
| 1101       | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт          | -9,955.50                | -9,989.10                 |
| 113        | Хөрөнгийн албан татвар                                   | 58,140.80                | 133,314.70                |
| 118        | Бусад татвар, төлбөр, хураамж                            | 142,304.20               | 351,805.00                |
| 12         | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 581,448.90               | 1,185,174.40              |
| 120        | Нийтлэг татварын бус орлого                              | 566,448.90               | 1,185,174.40              |
| 122        | Тусламжийн орлого  | 15,000.00                | 0                         |
| 13         | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 1,687,804.10             | 800,352.70                |
| <b>II</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                       | <b>1,616,913.70</b>      | <b>1,043,129.30</b>       |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>1,616,913.70</b>      | <b>1,043,129.30</b>       |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | <b>768,957.10</b>        | <b>1,002,479.30</b>       |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 378,471.70               | 481,046.00                |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 48,532.20                | 60,045.50                 |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 80,310.50                | 22,459.40                 |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 52,306.20                | 66,143.50                 |
| 2105       | Нормативт зардал   | 8,078.20                 | 1,506.90                  |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 14,236.50                | 9,931.00                  |
| 2107       | Томилголт, зочны зардал                                  | 8,068.00                 | 12,128.00                 |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,084.30                 | 101,288.10                |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 176,869.40               | 247,931.00                |
| <b>213</b> | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>847,956.60</b>        | <b>40,650.00</b>          |
| <b>III</b> | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>             | <b>1,030,147.90</b>      | <b>1,643,954.20</b>       |
| <b>V</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                   | <b>5,017,882.00</b>      | <b>1,172,584.70</b>       |
| <b>VI</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>   | <b>-3,987,734.10</b>     | <b>471,369.50</b>         |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

|      |   | /мянган төгрөгөөр/                      |                        |
|------|---|---|------------------------|
| Код: | Тайлангийн үзүүлэлт                             | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
| 1    | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 6,703,997.00                            | 6,703,997.00           |
| 10   | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 2,633,346.20                            | 2,633,346.20           |
| 3    | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 6,621,080.30                            | 6,621,080.30           |
| 2    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | -82,916.70                              | -82,916.70             |
| 9    | Тайлант үеийн үр дүн                            | -3,987,734.10                           | -3,987,734.10          |
| 11   | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 2,633,346.20                            | 2,633,346.20           |
| 20   | 2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл           | 5,132,836.30                            | 5,132,836.30           |
| 13   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 2,657,778.90                            | 2,657,778.90           |
| 12   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 24,432.70                               | 24,432.70              |
| 14   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -14,127.30                              | -14,127.30             |
| 15   | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 2,017,815.20                            | 2,017,815.20           |
| 19   | Тайлант үеийн үр дүн                            | 471,369.50                              | 471,369.50             |

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

|      |  | /мянган төгрөгөөр/     |                        |
|------|--|------------------------|------------------------|
| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
| I    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>            | <b>2,192,444.70</b>    | <b>1,553,022.30</b>    |
| 11   | ТАТВАРЫН ОРЛОГО  | 377,808.60             | 701,556.40             |
| 110  | Орлогын албан татвар                                     | 177,363.50             | 216,436.70             |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар                          | 187,319.00             | 226,425.80             |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт          | -9,955.50              | -9,989.10              |
| 113  | Хөрөнгийн албан татвар                                   | 58,140.80              | 133,314.70             |
| 118  | Бусад татвар, төлбөр, хураамж                            | 142,304.20             | 351,805.00             |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж                            | 1,472.00               | 5,024.70               |
| 1181 | Газрын төлбөр  | 140,832.30             | 346,780.30             |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 126,832.00             | 51,113.30              |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              | 111,832.00             | 51,113.30              |
| 122  | Тусламжийн орлого  | 15,000.00              | 0                      |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 1,687,804.10           | 800,352.70             |
| II   | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 | <b>1,461,535.60</b>    | <b>845,524.60</b>      |
| 21   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>1,461,535.60</b>    | <b>845,524.60</b>      |
| 210  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | <b>613,579.00</b>      | <b>804,874.60</b>      |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 378,471.70             | 487,717.90             |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 48,532.20              | 60,045.50              |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 79,712.10              | 22,459.40              |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 30,241.80              | 31,266.70              |
| 2105 | Нормативт зардал   | 0                      | 1,004.00               |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 14,236.50              | 10,000.00              |
| 2107 | Томиллот, зочны зардал                                   | 8,068.00               | 12,128.00              |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,035.60               | 101,288.10             |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 48,281.10              | 78,965.10              |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 847,956.60             | 40,650.00              |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)      | 730,909.10             | 707,497.70             |
| V    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>         | <b>678,115.60</b>      | <b>980,921.20</b>      |
| 22   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | <b>678,115.60</b>      | <b>980,921.20</b>      |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                      | 678,115.60             | 980,921.20             |
| VI   | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)    | -678,115.60            | -980,921.20            |
| VII  | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН   | 0                      | -130,000.00            |
| 23   | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               | 0                      | 130,000.00             |
| VIII | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b> | <b>52,793.50</b>       | <b>-403,423.50</b>     |
| 101  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 512,997.40             | 565,790.90             |
| 20   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 565,790.90             | 162,367.30             |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код    | Ү зүүлэлт  | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    |
|--------|--|--------------|--------------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                            | 1,963,811.90 | 1,853,006.19 |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ  | 803,841.90   | 772,818.71   |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                              | 803,191.90   | 772,168.71   |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                            | 495,584.60   | 487,717.90   |
| 210101 | Үндсэн цалин   | 308,426.90   | 306,403.10   |
| 210102 | Нэмэгдэл   | 137,484.50   | 138,289.06   |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт  | 11,824.00    | 11,259.99    |
| 210104 | Урамшуулал   | 37,849.20    | 31,765.73    |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл               | 61,348.20    | 60,045.46    |
| 210201 | Тэтгэврийн даатгал   | 41,717.10    | 41,383.36    |
| 210202 | Тэтгэмжийн даатгал   | 4,907.70     | 4,872.88     |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал  | 3,926.40     | 3,891.49     |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал   | 981.20       | 863.22       |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал  | 9,815.80     | 9,034.50     |
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                    | 117,286.60   | 113,045.34   |
| 210301 | Гэрэл, цахилгаан   | 47,602.90    | 45,525.11    |
| 210302 | Түлш, халаалт  | 68,757.50    | 66,594.02    |
| 210303 | Цэвэр, бохир ус  | 926.20       | 926.20       |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                             | 31,149.50    | 30,827.70    |
| 210401 | Бичиг хэрэг  | 4,083.90     | 4,034.70     |
| 210402 | Тээвэр, шатахуун   | 23,500.00    | 23,423.62    |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                           | 1,550.00     | 1,533.78     |
| 210404 | Ном, хэвлэл  | 240.00       | 60.00        |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                  | 1,775.60     | 1,775.60     |
| 2105   | Нормативт зардал   | 1,315.50     | 1,004.00     |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                  | 1,315.50     | 1,004.00     |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                            | 29,405.20    | 29,136.81    |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл                                      | 11,000.00    | 10,733.71    |
| 210604 | Урсгал засвар  | 18,405.20    | 18,403.10    |
| 2107   | Томилолт, зочны зардал                                       | 12,500.00    | 12,128.00    |
| 210702 | Дотоод албан томилолт  | 12,000.00    | 11,628.00    |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах                                  | 500.00       | 500.00       |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж     | 2,460.00     | 2,299.02     |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 900.00       | 838.00       |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 200.00       | 173.35       |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар                                   | 150.00       | 77.84        |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                | 100.00       | 100.00       |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                              | 1,080.00     | 1,080.00     |
| 210807 | Газрын төлбөр  | 30.00        | 29.83        |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                              | 52,142.30    | 35,964.46    |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                              | 52,142.30    | 35,964.46    |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 650.00       | 650.00       |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг                                       | 650.00       | 650.00       |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                      | 650.00       | 650.00       |
| 22     | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 1,014,970.00 | 950,187.48   |
| 223001 | Бусад хөрөнгө  | 1,014,970.00 | 950,487.80   |
| 23     | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ                   | 145,000.00   | 130,000.00   |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл  | 145,000.00   | 130,000.00   |

ЧОЙБАЛСАН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

|        |   |              |              |
|--------|---|--------------|--------------|
| III    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                    | 1,963,811.90 | 1,706,682.78 |
| 32     | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                    | 1,501,210.20 | 1,427,265.81 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс                              | 870,828.90   | 828,886.98   |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих           | 630,381.30   | 598,378.82   |
| 35     | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС             | 447,601.70   | 279,416.97   |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих         | 30,000.00    | 35,331.48    |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих         | 600.00       | 588.50       |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих                     | 417,001.70   | 243,496.99   |
| 36     | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ                 | 15,000.00    | 0.00         |
| 360001 | Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих                 | 15,000.00    | 0.00         |
| 4      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0.00         | 242,324.61   |
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00         | 96,001.20    |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Код    | Үзүүлэлт   | Гүйцэтгэл  |
|--------|--|------------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН  | 103,439.63 |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ  | 83,439.63  |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 43,439.63  |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал   | 439.00     |
| 210401 | Бичиг хэрэг  | 439.00     |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал  | 43,000.63  |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал  | 43,000.63  |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 40,000.00  |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг   | 40,000.00  |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 40,000.00  |
| 22     | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 20,000.00  |
| 2200   | Дотоод эх үүсвэрээр  | 20,000.00  |
| 223001 | Бусад хөрөнгө  | 20,000.00  |
| I      | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР   | 103,439.63 |
| 1311   | Нэмэлт санхүүжилтийн орлого  | 103,439.63 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 11,097.50  |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 91,277.63  |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 1,064.50   |
| III    | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)   | 0          |
| 9      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   | 0          |
| 10     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  | 0          |

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,229.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

#### Залруулсан алдаа:

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 92.9 сая төгрөгийн өртөгтэй “Эцэг малын үүлдвэр, угсааг сайжруулах” арга хэмжээг гэрээний дагуу хүлээн авч 83.7 сая төгрөгийг тайлант онд олгон 9.2 сая төгрөгийг өглөгөөр бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.

Аудитаар нийт 2,074.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 6 албан шаардлага хүргүүлсэн.

#### 3.1 Албан шаардлага

1. Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 85.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх 20.0 сая төгрөгийн тэрбум мод хөтөлбөр 55.3 хувийн, 30.0 сая төгрөгийн хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр 76.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
2. Сумын нийт орлого 772.9 сая төгрөг болж 55.6 сая төгрөг буюу 7.2 хувиар тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
3. ХХС-гийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн 48.7 сая төгрөгийн 6 зээл байгаа бөгөөд 19.5 сая төгрөгийн 2 зээлдэгчийн зээл нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд, 29.2 сая төгрөгийн 4 зээлдэгчийн зээлийг барагдуулах зохион байгуулалтын ажилбар хийгээгүй байна.

#### Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

4. Тайлант оны 984.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

#### Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

5. Шилэн дансны цахим хуудаст хагас жилийн санхүүгийн тайлан, дараа оны төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "... худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ... жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.1.4-д "... хагас жилийн тайланг 08

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор" оруулах гэж заасны дагуу байршуулан ажиллаагүй байна.

**Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.**

6. "Хулстай хөгжил" ОНӨААТҮГ нь 2023 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, Х тайлан ирүүлсэн, удирдлагыг нь томилоогүй байна. Сумын Засаг дарга нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаарх Засаг даргын бүрэн эрх: 78 дугаар зүйлийн 2.2-д "орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох", 2.3-д "орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын даргад оруулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Алдааны утга     | Нийт алдаа |            | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |          | Буруу тусган илэрхийлсэн |            | Үүнээс     |            |              |          | Зөвлөмж  |          |
|------------------|------------|------------|-----------------------------------|----------|--------------------------|------------|------------|------------|--------------|----------|----------|----------|
|                  | Тоо        | Дүн        | Тоо                               | Дүн      | Тоо                      | Дүн        | Залруулсан |            | Залруулаагүй |          | Тоо      | Дүн      |
|                  |            |            |                                   |          |                          |            | Тоо        | Дүн        | Тоо          | Дүн      |          |          |
| Өглөг тусгуулсан | 1          | 9.2        | -                                 | -        | 1                        | 9.2        | 1          | 9.2        | -            | -        | -        | -        |
| <b>Дүн</b>       | <b>1</b>   | <b>9.2</b> | <b>-</b>                          | <b>-</b> | <b>1</b>                 | <b>9.2</b> | <b>1</b>   | <b>9.2</b> | <b>-</b>     | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн утга  | Нийт зөрчил |      | Үүнээс        |     |                 |      |         |     |                                      |                     |   |     |
|--|-------------|------|---------------|-----|-----------------|------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|  |             |      | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |      | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|  | Тоо         | Дүн  | Тоо           | Дүн | Тоо             | Дүн  | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 85.6 хувийн гүйцэтгэлтэй хүрэх үр дүнг ханган ажиллаагүй | 1           | 16.0 |               |     | 1               | 16.0 |         |     |                                      |                     |   |     |
| Сумын нийт орлого 772.9 сая төгрөг болж 55.6 сая төгрөг буюу 7.2 хувиар тасарсан байна.  | 1           | 55.6 |               |     | 1               | 55.6 |         |     |                                      |                     |   |     |
| ХХС-гийн хугацаа хэтэрсэн 29.2 сая төгрөгийн 4 зээлдэгчийн   | 1           | 29.2 |               |     | 1               | 29.2 |         |     |                                      |                     |   |     |

**ЧОЙБАЛСАН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

|   |          |              |  |  |          |              |  |  |  |  |  |  |
|---|----------|--------------|--|--|----------|--------------|--|--|--|--|--|--|
| зээлийг<br>барагдуулах<br>зохион<br>байгуулалтын<br>ажилбар<br>хийгдээгүй<br>байна. |          |              |  |  |          |              |  |  |  |  |  |  |
| <b>Дүн</b>  | <b>3</b> | <b>100.8</b> |  |  | <b>3</b> | <b>100.8</b> |  |  |  |  |  |  |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын<br>нэр  | Нийт зөрчил |                | Үүнээс        |          |                 |                |          |          |
|--|-------------|----------------|---------------|----------|-----------------|----------------|----------|----------|
|  |             |                | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                | Зөвлөмж  |          |
|  | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн            | Тоо      | Дүн      |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>  |             |                |               |          |                 |                |          |          |
| Шилэн дансны цахим хуудаст хагас жилийн санхүүгийн тайлан, дараа оны төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг байршуулаагүй | 1           | 988.7          | -             | -        | 1               | 988.7          | -        | -        |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>988.7</b>   | <b>-</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>988.7</b>   | <b>-</b> | <b>-</b> |
| <b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>  |             |                |               |          |                 |                |          |          |
| Худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй  | 1           | 984.7          |               |          | 1               | 984.7          |          |          |
| "Хулстай хөгжил" ОНӨААТҮГ нь 2023 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, Х тайлан ирүүлсэн, удирдлагыг нь томилоогүй байна.   | 1           | 0              | -             | -        | 1               | 0              | -        |          |
| <b>Дүн</b>   | <b>2</b>    | <b>984.7</b>   | <b>-</b>      | <b>-</b> | <b>2</b>        | <b>984.7</b>   | <b>-</b> | <b>-</b> |
| <b>Нийт дүн</b>  | <b>3</b>    | <b>1,973.4</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>3</b>        | <b>1,973.4</b> | <b>-</b> | <b>-</b> |





ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 01/105 ДАА-2024/06/НА-СТА ТТ3 Чойбалсан хот  
1116 0305

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Хулстай хөгжил" ОНӨААТҮГ нь 2023 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, "Х"-тайлан ирүүлсэн, удирдлагыг нь томилоогүй байна.

Сумын Засаг дарга нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл, Орон нутгийн өмчийн талаарх Засаг даргын бүрэн эрх: 78 дугаар зүйлийн 2.2-д "орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох", 2.3-д "орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын даргад оруулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлдээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Хулстай хөгжил" ОНӨААТҮГ-ын удирдлагыг томилон, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чойбалсан сумын Засаг дарга П.Амгаланбаатар, санхүү албаны дарга Т.Тогтохцэрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА  
АХЛАХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ



011041300



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 02/106 АНН-2024/06/НА-СТА-ТТ3 Чойбалсан хот  
А.1160305

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн 29.2 сая төгрөгийн 4 зээлдэгчийн зээлийг барагдуулах зохион байгуулалтын ажил хийгээгүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.5 дахь "зээл зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх", 3.4.11 дэх "сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтуудтай хэрэгжүүлэн ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чойбалсан сумын Засаг дарга П.Амгаланбаатар, санхүү албаны дарга Т.Тогтохцэрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА  
АХЛАХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ

011041303



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 02/104 ДОА-2024/05/0А-СӨА-ТТЗ Чойбалсан хот  
01160305

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 984.7 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, ээрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим дэлгүүрт худалдан авах ажиллагааны жагсаалтыг байршуулах хүсэлтийг хүргүүлэх, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чойбалсан сумын Засаг дарга П.Амгаланбаатар, санхүү албаны дарга Т.Тогтохцэрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА  
АХЛАХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ

011041308



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 05/109 ДДН-2024/06/НА-СТА-ТТ3 Чойбалсан хот  
А-0760205

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Сумын төсвийн орлого 55.6 сая төгрөг буюу 7.2 хувиар тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.2.2-д "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх"; 4.1.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ" 4.1.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн орлогыг батлагдсан нэр төрлөөр биелүүлэн ажиллах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чойбалсан сумын Засаг дарга П.Амгаланбаатар, санхүү албаны дарга Т.Тогтохцэрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА  
АХЛАХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ

011041313



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 04/103-ААА-2024/06/НА-СТА-ТТЗ Чойбалсан хот  
А.160305

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст хагас жилийн санхүүгийн тайлан, дараа оны төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "... худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ... жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.1.4-д "... хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор" оруулах гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд дараа оны төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг байршуулах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чойбалсан сумын Засаг дарга П.Амгаланбаатар, санхүү албаны дарга Т.Тогтохцэрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА  
АХЛАХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ

011041309



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 06/10 ДАА-2024/06/НА-СТА-ТТ3 Чойбалсан хот  
А1160505

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 50.0 сая төгрөгийн 2 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг хангаж ажиллах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чойбалсан сумын Засаг дарга П.Амгаланбаатар, санхүү албаны дарга Т.Тогтохцэрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА  
АХЛАХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ



011041316

